

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/311/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг
Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetseg.i@audit.mn
Аудитор: Т.Нямсүрэн
Утас: 260512 Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn
Дөлгөөнхайрхан уул Аудит ХХК-ийн захирал: Б.Пүрэвдулам
Утас: 70005711 Цахим хаяг: dulguunkhairkhanuulaudit09@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	8
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	26
6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	28

Товчилсон үгсийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЧИНГИС ХААН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН
ЗАХИРАЛ, АКАДЕМИЧ С.ЧУЛУУН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.05 № 06/449

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Чингис хаан үндэсний музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Чингис хаан үндэсний музей нь тайлант онд Монгол банкны Эрдэнэсийн сантай хамтран бүтээж буй Дэлхийн Мянганы суут хүмүүн, Их Чингис хааны хүндэтгэл оршоосон Их хааны өргөөн дэх Алтан хөшөө, Шүтээн Их Цагаан туганд шүншиг өргөх ёслолын нээлтийг зохион байгуулж, нийт 87,994.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 8,953,229.2 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 25,000.0 мянган төгрөгийн хандив тусламж болон бусад орлого нийт 8,978,229.2 мянган төгрөгийг төвлөрснөөс 3,630,171.9

мянган төгрөгийг зарцуулж, 5,348,057.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлэн авлага дансанд бүртгэсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЦНАРАНЧИМЭГ

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,474,794,877.70	7,564,872,068.45
33	АВЛАГА	4,435,432,701.88	5,368,149,729.11
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,435,432,701.88	5,367,591,962.21
33500	Бусад авлага	-	557,766.90
33510	Байгууллагаас авах авлага	-	557,766.90
35	БАРАА МАТЕРИАЛ	1,669,905,675.82	1,811,935,839.34
35100	Түүхий эд материал	338,000.00	105,000.00
35130	Эм боох материал	338,000.00	105,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	239,178,591.50	349,392,721.16
35400	Хангамжийн материал	1,430,389,084.32	1,462,438,118.18
35410	Бичиг хэргийн материал	11,229,690.00	3,406,120.00
35420	Аж ахуйн материал	192,990,755.40	222,028,989.80
35430	Сэлбэг хэрэгсэл	2,519,000.00	2,519,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,827,000.00	2,755,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,218,822,638.92	1,231,728,408.38
36	НӨӨЦИЙН БАРАА	369,456,500.00	384,786,500.00
36100	Барааны нөөц	369,456,500.00	384,786,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	103,108,159,648.83	101,057,167,437.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	103,108,159,648.83	101,057,167,437.03
39200	Биет хөрөнгө	102,465,751,538.04	100,386,529,403.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	71,758,617,623.00	70,873,151,744.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,113,408,284.56)	(3,267,764,999.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	499,741,650.00	499,741,650.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(160,441,650.00)	(202,441,650.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,085,315,336.04	8,535,858,593.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,669,516,379.96)	(2,690,836,717.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,112,368,549.00	10,440,103,066.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,739,759,402.69)	(2,676,866,861.03)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	18,306,812,628.15	18,465,402,628.15
3921301	Үзмэр	6,793,273,192.83	6,928,963,192.83
3921302	Түүх соёлын дурсгалт зүйлс	11,513,539,435.32	11,536,439,435.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,019,500.00	5,019,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,040,201.94)	(4,571,972.54)
39217	Номын фонд	385,042,171.00	409,734,421.00
39300	Биет бус хөрөнгө	642,408,110.79	670,638,033.31
39301	Программ хангамж	16,074,000.00	16,074,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(9,812,400.00)	(13,027,200.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	708,293,050.00	853,293,050.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(72,146,539.21)	(185,701,816.69)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (3=1+2)	109,582,954,526.53	108,622,039,505.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,606,740,232.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,606,740,232.00
41300	Өглөг	-	1,606,740,232.00
41360	Бусад өглөг	-	1,606,740,232.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	827,689,932.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	779,050,300.00

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	109,582,954,526.53	107,015,299,273.48
51	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	109,582,954,526.53	107,015,299,273.48
51200	Хуримтлагдсан үр дүн	109,582,954,526.53	107,015,299,273.48
51210	Өмнөх үеийн үр дүн	92,275,781,581.89	109,609,588,394.82
51220	Тайлант үеийн үр дүн	17,307,172,944.64	(2,594,289,121.34)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	109,582,954,526.53	108,622,039,505.48

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	29,869,914,183.38	14,601,758,255.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,596,262,573.39	453,516,637.52
1200	Нийтлэг татварын бус орлого	15,988,861,054.39	453,516,637.52
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,904,183,248.39	435,086,637.52
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	84,677,806.00	18,430,000.00
1220	Тусламжийн орлого	1,607,401,519.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	1,607,401,519.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,273,651,609.99	14,148,241,618.23
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,259,405,700.00	5,170,012,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,259,405,700.00	5,170,012,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,014,245,909.99	8,978,229,218.23
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,568,967,885.00	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,229,861,765.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,215,416,259.99	8,953,229,218.23
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,562,741,238.74	12,766,403,982.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,562,741,238.74	12,766,403,982.84
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		11,489,629,640.93
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,363,184,167.07	3,849,719,317.85
210101	Үндсэн цалин	2,029,594,783.62	2,325,376,793.37
210102	Нэмэгдэл	555,215,494.02	694,892,874.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	437,809,000.00	491,349,000.00
210104	Урамшуулал	261,518,518.00	338,100,650.00
210105	Гэрээт ажлын цалин	79,046,371.43	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	417,462,641.07	480,322,436.95
210201	Тэтгэврийн даатгал	284,225,227.73	325,368,910.88
210202	Тэтгэмжийн даатгал	33,582,862.06	38,571,122.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,022,533.36	23,589,762.16
210204	Ажилгүйдлийн даатгал	15,784,281.08	18,549,771.37
210205	Эрүүл мэндийн даатгал	64,847,736.84	74,242,869.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,059,854.37	360,830,308.33
210301	Гэрэл, цахилгаан	231,409,418.70	279,544,468.31
210302	Түлш, халаалт	59,364,867.67	56,183,364.09
210303	Цэвэр, бохир ус	23,285,568.00	25,102,475.93
2104	Хангамж, бараа материалын зардал	175,270,193.02	158,122,695.60
210401	Бичиг хэрэг	37,293,405.00	28,310,210.00
210402	Тээвэр, шатахуун	30,090,729.82	52,293,304.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,335,906.20	30,174,203.00
210404	Ном, хэвлэл	690,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	91,860,152.00	47,344,978.60
2105	Нормативт зардал	-	233,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	233,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,827,800.00	15,853,000.00

**Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,188,800.00	11,253,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,969,000.00	-
210604	Урсгал засвар	4,670,000.00	4,600,000.00
2107	Томилолт, зочны зардал	307,902,954.00	342,272,435.50
210701	Гадаад албан томилолт	20,000,000.00	107,790,085.50
210702	Дотоод албан томилолт	287,902,954.00	234,482,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,588,576,907.70	1,851,272,002.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,461,821,162.15	1,750,920,635.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,844,217.55	63,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,456,528.00	31,851,367.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,796,950,117.94	4,431,004,444.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	707,097,359.38	851,980,541.88
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	75,142,734.08	99,026,850.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	3,014,710,024.48	3,479,997,052.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	589,506,603.57	1,276,774,341.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	573,776,000.00	985,954,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,608,000.00	19,534,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	556,168,000.00	966,420,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,730,603.57	290,819,641.91
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,730,603.57	290,819,641.91
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 3=1-2	17,307,172,944.64	7,151,369,102.64
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	13,530,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	13,530,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - бараа материал	-	13,530,000.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6=3+4-5)	17,307,172,944.64	(2,594,289,121.34)

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	14,445,376,583.51	14,148,241,618.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,445,376,583.51	14,148,241,618.23
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,259,405,700.00	5,170,012,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,259,405,700.00	5,170,012,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,185,970,883.51	8,978,229,218.23
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,568,967,885.00	15,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,229,861,765.00	10,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,387,141,233.51	8,953,229,218.23
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,307,664,579.99	4,265,617,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,445,376,583.51	14,148,241,618.23
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,420,437,278.06	8,215,302,014.11
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,330,626,345.10	3,830,592,249.52
210101	Үндсэн цалин	2,000,461,772.11	2,325,315,112.54
210102	Нэмэгдэл	554,878,251.51	694,317,045.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	437,241,680.47	490,400,106.20
210104	Урамшуулал	260,844,549.58	320,559,985.25
210105	Гэрээт ажлын цалин	77,200,091.43	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	414,712,321.07	477,957,728.74
210201	Тэтгэврийн даатгал	280,428,627.73	323,066,349.29
210202	Тэтгэмжийн даатгал	33,582,862.06	38,555,586.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,022,533.36	23,581,993.84
210204	Ажилгүйдлийн даатгал	15,784,281.08	18,542,003.05
210205	Эрүүл мэндийн даатгал	65,894,016.84	74,211,796.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	314,559,854.37	360,830,308.33
210301	Гэрэл, цахилгаан	231,409,418.70	279,544,468.31
210302	Түлш, халаалт	59,864,867.67	56,183,364.09
210303	Цэвэр, бохир ус	23,285,568.00	25,102,475.93
2104	Хангамж, бараа материалын зардал	188,461,012.02	145,792,171.00
210401	Бичиг хэрэг	43,059,915.00	22,213,425.00
210402	Тээвэр, шатахуун	20,520,899.82	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,335,906.20	14,658,336.00
210404	Ном, хэвлэл	690,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,854,291.00	93,920,410.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,120,205.00	55,545,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,546,000.00	40,547,390.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	55,995,205.00	14,998,310.00
210604	Урсгал засвар	6,579,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	319,399,784.00	377,494,339.50
210701	Гадаад албан томилолт	20,000,000.00	107,790,085.50
210702	Дотоод албан томилолт	299,399,784.00	269,704,254.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,657,906,127.47	2,739,004,836.02

**Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,516,115,782.92	2,654,689,069.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	100,844,217.55	63,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,491,127.00	20,815,767.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,651,629.03	228,084,681.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,335,894.95	4,985,860.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	81,315,734.08	223,098,821.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,024,939,305.45	5,932,939,604.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	573,776,000.00	274,528,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,608,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	556,168,000.00	274,528,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,451,163,305.45	5,658,411,604.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,730,603.57	310,354,241.91
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,435,432,701.88	5,348,057,362.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3=1-2)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8=3+6+7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	92,254,091,691.75	92,254,091,691.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	21,689,890.14	21,689,890.14
3	Залруулсан үлдэгдэл	-	-	92,275,781,581.89	92,275,781,581.89
9	Тайлант үеийн үр дүн	-	-	17,307,172,944.64	17,307,172,944.64
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	109,582,954,526.53	109,582,954,526.53
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-	-	26,633,868.29	26,633,868.29
13	Залруулсан үлдэгдэл	-	-	109,609,588,394.82	109,609,588,394.82
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,594,289,121.34)	(2,594,289,121.34)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	107,015,299,273.48	107,015,299,273.48

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,330,147,600.00	4,859,658,158.09	470,489,441.91	91.2
12	Татварын бус орлого	5,330,147,600.00	4,859,658,158.09	470,489,441.91	91.2
122	Тусламжийн орлого	5,330,147,600.00	4,859,658,158.09	470,489,441.91	91.2
122005	Төсвөөс санхүүжих	5,330,147,600.00	4,859,658,158.09	470,489,441.91	91.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,330,147,600.00	4,859,658,158.09	470,489,441.91	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,330,147,600.00	4,859,658,158.09	470,489,441.91	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,294,013,900.00	4,859,658,158.09	434,355,741.91	91.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,110,180,000.00	3,830,592,249.52	279,587,750.48	93.2
210101	Үндсэн цалин	2,668,258,600.00	2,325,315,112.54	342,943,487.46	87.1
210102	Нэмэгдэл	625,439,600.00	694,317,045.53	(68,877,445.53)	111.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	570,456,000.00	490,400,106.20	80,055,893.80	86.0
210104	Урамшуулал	246,025,800.00	320,559,985.25	(74,534,185.25)	130.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	510,532,100.00	477,957,728.74	32,574,371.26	93.6
210201	Тэтгэврийн даатгал	347,788,800.00	323,066,349.29	24,722,450.71	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	40,677,800.00	38,555,586.33	2,122,213.67	94.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,463,300.00	23,581,993.84	(3,118,693.84)	115.2
210204	Ажилгүйдлийн даатгал	20,319,700.00	18,542,003.05	1,777,696.95	91.3
210205	Эрүүл мэндийн даатгал	81,282,500.00	74,211,796.23	7,070,703.77	91.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	294,830,700.00	294,830,308.33	391.67	100
210301	Гэрэл, цахилгаан	231,544,800.00	231,544,468.31	331.69	100
210302	Түлш, халаалт	41,801,800.00	41,183,364.09	618,435.91	98.5
210303	Цэвэр, бохир ус	21,484,100.00	22,102,475.93	(618,375.93)	102.9
2104	Хангамж, бараа материалын зардал	39,009,000.00	32,158,891.00	6,850,109.00	82.4
210402	Тээвэр, шатахуун	2,992,800.00	2,383,685.00	609,115.00	79.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,061,300.00	14,658,336.00	1,402,964.00	91.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,954,900.00	15,116,870.00	4,838,030.00	75.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,092,400.00	-	52,092,400.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,092,400.00	-	52,092,400.00	-
2107	Томилолт, зочны зардал	56,344,100.00	56,344,100.00	6.50	100
210701	Гадаад албан томилолт	56,344,100.00	56,344,100.00	6.50	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	185,090,400.00	160,909,027.00	24,181,373.00	86.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	140,093,300.00	140,093,260.00	40.00	100

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	4,977,100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,039,900.00	-	4,039,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,400.00	-	358,400.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	179,200.00	-	179,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	35,442,500.00	20,815,767.00	14,626,733.00	58.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,935,200.00	6,865,860.00	39,069,340.00	14.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,055,200.00	4,985,860.00	39,069,340.00	11.3
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,880,000.00	1,880,000.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,133,700.00	-	36,133,700.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,133,700.00	-	36,133,700.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,534,700.00	-	19,534,700.00	-
	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,599,000.00	-	16,599,000.00	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	169	154	15	91.1
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	138	123	15	89.1
620003	Үйлчлэх ажилтан	30	30	-	100

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,978,229,218.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,978,229,218.23
122	Тусламжийн орлого	8,978,229,218.23
1221	Хандив тусламж /дотоод/	8,978,229,218.23
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,978,229,218.23
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	15,000,000.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,978,229,218.23
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,630,171,856.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,630,171,856.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,355,643,856.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	48,000,000.00
210302	Түлш, халаалт	15,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	113,633,280.00
210401	Бичиг хэрэг	19,829,740.00
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	78,803,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,545,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,547,390.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,998,310.00
2107	Томилолт, зочны зардал	321,150,246.00
210701	Гадаад албан томилолт	51,445,992.00
210702	Дотоод албан томилолт	269,704,254.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,578,095,809.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,514,595,809.02
210803	Даатгалын үйлчилгээ	63,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,218,821.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	221,218,821.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,622,585,362.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	274,528,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	274,528,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	5,348,057,362.21
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(5,348,057,362.21)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(5,348,057,362.21)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Чингис хаан үндэсний музей нь Чингис хааны болон Монгол хаад язгууртны түүхэнд холбогдох соёлын үнэт зүйлийг цуглуулах, судлах, хадгалах, сурталчлах, лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүрэг бүхий соёл, шинжлэх ухааны байгууллага бөгөөд, Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Чингис хаан үндэсний музей нь эрхэм зорилгоо “Монголын болон дэлхийн түүхэн дэх гарамгай удирдагч Чингис хаан, түүний өвөг дээдэс болох Их хааны залгамжлагч хаад язгууртны түүх, соёлын өвийг судлан цуглуулж, сурталчлан таниулах Үндэсний хэмжээний соёл, шинжлэх унааны цогц төв болж төлөвшинө” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Чингис хаан үндэсний музей нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Музейн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Тайлант хугацаанд театрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогын чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дугаар тогтоол "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ыг шинэчлэн батлах тухай;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/05 дугаар тушаалаар дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай;

Чингис хаан үндэсний музей нь удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2024 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан байна. Дээрх шалгалтаар тус байгууллага шилэн дансны хөтлөлт дээр 93.1 хувь, үнэн зөв, бодитой, иж бүрэн байдалд 80.5 хувийн үнэлгээ тус тус авсан байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүнийг гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чингис хаан үндэсний музей нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайдын 2022 оны А/02 дугаар тушаалаар баталсан соёлын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцсэн загвараар холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, үйл ажиллагааны онцлогт, тохирсон бодлогын баримт бичигт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийг хөтөлж иржээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чингис хаан үндэсний музей нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 960,915.0 мянган төгрөгөөр буюу 0.9 дахин буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	4,435,432.7	5,367,149.7	932,717.0
Бараа материал	1,669,905.7	1,811,935.8	142,030.2
Нөөцийн бараа	369,456.5	384,786.5	15,330.0
Үндсэн хөрөнгө	103,108,159.6	101,057,167.4	(2,050,992.2)
Нийт хөрөнгө	109,582,954.5	108,622,039.5	(960,915.0)
Өр төлбөр	-	1,606,740.2	1,606,740.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	109,582,954.5	107,015,299.3	(2,567,655.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	109,582,954.5	108,622,039.5	(960,915.0)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данснууд байна. Үүнд:

Авлага дансны үлдэгдэл 5,367,149.7 мянган төгрөг болж, 932,717.0 мянган төгрөгөөр өссөн нь авлагын үлдэгдэлд Сангийн яамнаас авах нэмэлт санхүүжилтийн авлага 5,368,149.7 мянган төгрөг, “Гэрэгэ пос систем ХХК”-аас музейн үзвэрийн тасалбарын орлого 557.8 мянган төгрөгийн авлагыг тус тус бүртгэсэнтэй холбоотой;

Бараа материал дансны үлдэгдэл 1,811,935.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 142,030.2 мянган төгрөгөөр өссөн нь 1,102,993.7 мянган төгрөгийн бараа худалдан авч, 947,733.5 мянган төгрөгийн барааг зарцуулж, 13,530.0 мянган төгрөгийн барааг шилжүүлсэнтэй холбоотой;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 101,057,167.4 мянган төгрөг болж, 2,050,992.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,111,648.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 30,000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг худалдан авч, 3,120.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 900.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл, 6,266.0 мянган төгрөгийн номын фонд тус тус хандиваар, 135,690.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл, 100,000.0 мянган төгрөгийн газрыг балансаас балансад шилжүүлэн, 189,110.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг дахин үнэлгээний нэмэгдлээр тус тус орлогоор бүртгэлд тусгасан, тайлант хугацаанд 3,479,997.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой тус тус холбоотой байна.

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны “Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай” 299 дүгээр тогтоолоор “Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн” цогцолборын барилга 1,995,300.0 мянган төгрөг, “Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн” цогцолборын барилгын интерьер, дотоод уран сийлбэр шинэчлэл, гадна цахилгаан 3,025,300.0 мянган төгрөг, “Их хуралдай” цогцолборын барилгын зоорины давхрын ажил, гадна тохижилт, шугам сүлжээ 2,862,700.0 мянган төгрөг, нийт 7,883,300.0 мянган төгрөгийн хөрөнгийг 2024 оны санхүүгийн тайланд нийт дүнгээр барилга дансанд бүртгэж тайлагнасныг “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн А1/1496 дугаартай албан бичгийг үндэслэн 2025 оны санхүүгийн тайландаа барилга данснаас тус дүнгээр хасагдуулаг хийж, хөрөнгүүдийг ангилал бүрээр салгаж тайлагнасан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,606,740.2 мянган төгрөг байгаа нь байгууллагад өгөх өглөг 827,689.9 мянган төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 779,050.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Худалдан авах гэрээтэй байгууллага болон хувь хүмүүст олгох ёстой өр төлбөрүүд 2025 оны 9 дүгээр сараас хойш төрийн сан дээр гүйлгээ гарахгүй байснаас үүдэн үүссэн бөгөөд тус өглөг, авлагуудыг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулж тайланд тусгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 107,015,299.3 мянган төгрөг болж, 2,567,655.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн дүнгээс шалтгаалжээ.

Программ хангамжийн талаар “Dynamic 1.0” программ ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 9,309,029.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн. Үүнээс үндсэн үйл ажиллагааны зардлыг 4,228,600.7 мянган төгрөгөөр бууруулж, төрийн чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 15,271.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 5,095,699.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Тодотголоор “Хүннү язгууртны оршуулгын цогцолбор дурсгалууд”-ыг ЮНЕСКО-ийн дэлхийн өвд бүртгүүлэх ажлын хүрээнд шинжээчийг Монгол Улсад ажиллуулахад шаардагдах зардлыг болон гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд нийт 234,448.1 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж, 5,330,147.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,170,012.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 4,859,658.2 мянган төгрөгийг зарцуулж, 310,354.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлснээс буцаан авах авлагаар 19,534.6 мянган төгрөгийг тайлагнасан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	5,294,013.9	4,859,658.2	434,355.7	91,8

**Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2	81569-Төрийн чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	36,133.7	-	36,133.7	-
	Дүн	5,330,147.6	4,859,658.2	470,489.4	91,2

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Соёл, спорт, аялал, зуучлал, залуучуудын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 01/2515 дугаартай албан бичгээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу орон тоог хасаж, музейн захирлын 2025 оны 10 дүгээр сарын 01-ний өдрийн А/173 дугаар тушаалаар цомхотгол хийж 169 орон тоотой байсныг орон тоог 9 хувиар бууруулж, орон тооны дээд хязгаарыг 154 байхаар тогтоон шинэчлэн баталж хэрэгжүүлсэн байна.
2. Монгол улсын засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2, 8.4, Хөдөлмөрийн дотоод журмын 11.2 заалтуудыг тус тус үндэслэн албан хаагчдын ажилдаа ирэх буцах нийтийн тээврийн унааны зардлыг өдрийн 3.0 мянган төгрөг, хоолны зардлыг 10.0 мянган төгрөг байхаар шинэчлэн баталж, тайлант хугацаанд унаа хоолны зардалд 570,456.0 мянган төгрөг төлөвлөж, 490,400.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.
3. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 30 албан хаагч олон улсын хурал, арга хэмжээнд оролцон, ижил төрлийн чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллагын үйл ажиллагаатай танилцан, туршлага солилцож гадаад албан томилолтонд 56,344.1 мянган төгрөг зарцуулсан байна.
4. 2025 онд нийт 5 зорилтын хүрээнд 12 төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөө батлагдсан. Жилийн эцсийн байдлаар албан хаагчдад нийт 29 удаагийн сургалтад давхардсан тоогоор 690 албан хаагчийн оролцоог ханган, чадавхжуулах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулсан бөгөөд дотоод сургалтад 2,070.8 мянган төгрөг зарцуулсан байна.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний 10,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, төлбөр тооцоо гаргасан байна.
6. Тайлант хугацаанд хамаарах төрд учирсан хохирол байхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 8,953,229.2 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 25,000.0 мянган төгрөгийн хандив тусламж болон бусад орлого, нийт 8,978,229.2 мянган төгрөгийг төвлөрснөөс 3,630,171.9 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж, 5,348,057.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлснийг буцаан авах авлагаар тооцоо нийлж, тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2,595,000.0 мянган төгрөгийн 13 ажил, үйлчилгээг зохион байгуулахаар төлөвлөж, музейд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах (Хэнтий Биндэр) 380,000.0 мянган төгрөгийн тендер болох Их хуралдай цогцолборын менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт орчны дагуу 2026 оны төлөвлөгөө рүү шилжүүлсэн. Нийт 6 багцад нээлттэй, 6 харьцуулалтын аргаар шалгаруулалт явуулж 1,802,895.0 мянган төгрөгийн гэрээ хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чингис хаан үндэсний музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Чингис хаан үндэсний музей, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дөлгөөнхайрхан уул аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Янжмаа, аудиторын туслах А.Золзаяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер С.Долгорсүрэн, захирал Б.Пүрэвдулам, Санхүүгийн аудитын газрын аудитор Т.Нямсүрэн, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 12,562,741.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 125,627.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан ба төсвийн хэтрэлт гаргаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 153,740.6 мянган төгрөгийн 4 зөрчлөөс, 153,740.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих нийт 135 мэдээлэл мэдээлэхээс хандив тусламжийн орлого, зарцуулалтын тайлан, худалдан авах ажиллагаа төлөвлөгөө, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан зэрэг 153,740.6 мянган төгрөгийн 9 мэдээлэл хугацаа хоцроосон. Мэдээллийг хоцроож байршуулсан хугацаа нь тус музейн ерөнхий нягтлан бодогч 02 дугаар сарын сүүлээр ажлаа хүлээлгэн өгч, дараагийн ерөнхий нягтлан бодогч томилогдох хугацааны хооронд бөгөөд энэ хооронд шилэн данс хариуцах ажилтан томилогүй байснаас шалтгаалжээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй, байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус музейд ашиглагдаж байгаа 3 автомашины улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий дугаартай болгож хэрэглэхийг өмнөх аудитаар зөвлөмж өгсөн. Музейн 84-47 УБД улсын бүртгэлтэй дугаартай “Форд эверест” маркийн автомашин нь малтлага судалгаанд ашигладаг судалгааны олдвор болон тусгай үзэсгэлэнгийн хосгүй үнэт дурсгал, гадагшаа болон гадаад улсаас ирсэн үзмэр эд өлгийн зүйл тээвэрлэдэг учир соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу аюулгүй байдлын үүднээс тод дэвсгэр ашигладаггүй болно, мөн 08-63 УБТ улсын бүртгэлийн дугаартай тээврийн хэрэгсэл нь ашиглалтын хугацаа дууссан тул дахин үнэлгээжүүлэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдох хүсэлтийг гаргахаар төлөвлөн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэн ажиллаж байна гэсэн тайлбарыг үндэслэн аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ." гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх, үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж тус ТХТ хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх боломжгүй эсэх талаар дээд шатны төсвийн захирагч болон холбогдох бусад байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлж, ажиллах албан шаардлага өгөв.

4.4.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус музейн Ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтод "худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах" гэж заасан нь худалдан авах ажиллагааг зохион

байгуулах чиг үүргийн салангид байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дотоод хяналт хэрэгжихгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т "хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;" Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2-т "хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах;" 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолт дээрх "Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах" чиг үүргийг өөрчлөн, өөр албан тушаалтанд хариуцуулах, зөрчлийг арилгах зөвлөмжийг өгөв.

4.4.4 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Музейн захирлын тушаалаар "Цалин, үндсэн хөрөнгийн нягтлан бодогч" албан тушаалтай ажилтан "Үндсэн хөрөнгө, кассын нярав" гэсэн албан тушаалын албыг хавсран хийж гүйцэтгүүлэхээр тушаал гарган ажиллуулсан нь үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт суларч нэг хүнд ноогдох ажлын байрны ачаалал бий болж, гүйцэтгэлийн чанар буурах эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т "хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан хаагчтай хамаарал бүхий этгээд нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" зарчим алдагдаж, 16 дугаар зүйлийн 16.5.9-д "дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Үндсэн хөрөнгө, кассын нярав" гэсэн чиг үүргийн давхардлыг салгаж, орон тоо бүтцэд тохируулан шийдвэр гаргаж ажиллах зөвлөмжийг өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн данснуудад горим, сорил хэрэгжүүлж, аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар 3,069.5 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 246,377.1 мянган төгрөгийн зөрчлөөс 242,783 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах байх 3,594.1 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснөөс төлбөрийн акт, зөвлөмжийг бүрэн

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулах, мөн тод дэвсгэрт бүхий улсын дугаар хэрэглээгүй аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байгаа тул тайлант хугацаанд албан шаардлага хүргүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	242,783.0	2	230,280.8	96.7
Зөвлөмж	5	3,594.1	5	3,114.7	82.4
Нийт дүн	7	246,377.1	7	233,395.5	89.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмыг байгууллагын үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлд бүрэн нэвтрүүлэн, санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад нийцүүлэн үнэн зөв бэлтгэхэд анхаарч ажиллах, уг журмын гуравдугаар хавсралтаар баталсан "Дансны жишиг жагсаалт"-ыг дагаж мөрдөн сайжруулсан эсэхийг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,460.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 4,200.0 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 6,260.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 10,460.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 125,627.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс бага байгааг үндэслэн “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Чингис хаан Үндэсний музейн захирлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Б/61 дугаартай тушаалаар томогдсон Захиргаа, удирдлагын хэлтсийн хуульч, эрх зүйч нь 2025 онд гадаад улсад магистрын зэрэгт суралцахаар явсан. Тус ажилтантай зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээ байгуулан хоолны хөнгөлөлт 3,320.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 570.0 мянган төгрөг, нийт 3,890.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зайнаас ажилласан ажилтанд олгосон хоол, унааны хөнгөлөлт нийт 3,890.0 мянган төгрөгийг холбогдох ажилтнаар нөхөн төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Томилолтоор ажилласан 4 албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлт нийт 310.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон нийт 310.0 мянган төгрөгийг холбогдох албан тушаалтнуудаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутагт байрлах цогцолбор газарт туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй 5 ажилтанд нийт 6,260.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгоогүй мөн тус 5 албан хаагч болон 2 үндсэн ажилтнаар ажиллаж байсан ажилтнуудад хөдөлмөрийн

харилцаа дуусгавар болох үед ажилласан хугацааны ээлжийн амралтын олговор олгоогүй байна.

Энэ Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3-т "Туршилтаар ажиллах ажилтны үндсэн цалинг тухайн ажлын байрны үндсэн цалингаас багагүй байхаар тогтоох бөгөөд түүнд нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговрыг энэ хуульд заасны дагуу олгоно" гэснийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Ажил олгогчоос ажилтанд олгох нэмэгдэл хөлс болон ээлжийн амралтын нөхөн олговрыг хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв тооцож, олгож байх зөвлөмж өглөө.

5.2.2 Цалингийн зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаа, олон нийтийн төвийн Аюулгүй байдал инженерийн багийн 4 камер хянагч, 3 сантехникч нар нь 24/72 цагаар ээлжид ажилладаг бөгөөд тус ажилчдад илүү цаг болон шөнө цагийн нэмэгдлийг тооцож олгоогүй.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.3-т "Ажил олгогч ажилтантай тохиролцсоны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол ээлжийн ажлын цагийн үргэлжлэлийг дөрвөөс илүүгүй цагаар уртасган зохион байгуулж болно. Энэ тохиолдолд ажилтан долоо хоногт 40 цагаас илүү ажилласан бол түүнд илүү ажилласан цагийн хөлсийг энэ хуулийн 109.1-т заасны дагуу нэмж олгоно", 91 дүгээр зүйлийн 91.1-т "Ажилтныг ажил олгогчийн санаачилгаар ердийн ажлын өдрийн үргэлжлэл, ээлжийн ажлын цаг, долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл болон ажлын цагийг нэгтгэн бодох ердийн ажлын цагийн нийлбэрээс хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно", 109 дүгээр зүйлийн 109.8-т "Ажилтныг ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагт ажиллуулбал шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журмын дагуу ажилтны цалин хөлсийг зөв тооцож, олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Томилолтоор ажилласан болон ажлаас халагдсан 4 албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан 310.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	310.0	1	310.0	-	-	-	-	-	-	-	-
2	Чингис хаан Үндэсний музейн Захиргаа, удирдлагын хэлтэст хуульч, эрх зүйч ажилтан 2025 онд гадаад улсад магистр суралцахаар явсан. Тус ажилтантай зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээ байгуулж, хоолны хөнгөлөлт 3,320.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 570.0 төгрөг нийт 3,890.0 мянган төгрөг олгосон байна.	1	3,890.0	1	3,890.0	-	-	-	-	-	-	-	-
3	Орон нутагт байрлах цогцолбор газарт туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй 5 ажилтанд нийт 6,260.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгоогүй мөн тус 5 албан хаагч болон 2 үндсэн ажилтнаар ажиллаж байсан ажилтнуудад хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох үед ажилласан хугацааны ээлжийн амралтын олговор олгоогүй байна.	1	6,260.0	-	-	-	-	1	6,260.0	-	-	-	-

/мянган төгрөгөөр/

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	Байгууллагын үйл ажиллагаа, олон нийтийн төвийн аюулгүй байдал инженерийн багийн 4 камер хянагч, 3 сантехникч нар нь 24/72 цагаар ээлжид ажилладаг бөгөөд тус ажилчдад илүү цаг болон шөнө цагийн нэмэгдлийг тооцож олгоогүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
	Дүн	4	10,460.0	2	4,200.0	-	-	2	6,260.0	-	-	-	-

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1.1	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих нийт 135 мэдээлэл мэдээлэхээс хандив тусламжийн орлого, зарцуулалтын тайлан, худалдан авах ажиллагаа төлөвлөгөө, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан зэрэг 153,740.6 мянган төгрөгийн 9 мэдээлэл хугацаа хоцроосон. Мэдээллийг хоцроож байршуулсан хугацаа нь тус музейн ерөнхий нягтлан бодогч 2 дугаар сарын сүүлээр ажлаа хүлээлгэн өгч, дараагийн ерөнхий нягтлан бодогч томилогдох хугацааны хооронд бөгөөд энэ хооронд шилэн данс хариуцах ажилтан томилоогүй байснаас шалтгаалжээ.	1	153,740.6	1	153,740.6	-	-
	Дүн	1	153,740.6	1	153,740.6	-	-
2	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
2.1	Тус музейд ашиглагдаж байгаа 3 автомашины улсын дугаарыг тод дэвсгэр өнгө бүхий дугаартай болгож хэрэглэхийг өмнөх аудитаар зөвлөмж өгсөн. Музейн 84-47 УБД улсын бүртгэлтэй дугаартай "Форд эверест" маркийн автомашин нь малтлага судалгаанд ашигладаг судалгааны олдвор болон тусгай үзэсгэлэнгийн хосгүй үнэт дурсгал, гадагшаа болон гадаад улсаас ирсэн үзмэр эд өлгийн зүйл тээвэрлэдэг учир соёлын биет өвийг зөөж тээвэрлэх журмын дагуу аюулгүй байдлын үүднээс тод дэвсгэр ашигладаггүй болно, мөн 08-63 УБТ улсын бүртгэлийн дугаартай тээврийн хэрэгсэл нь ашиглалтын хугацаа дууссан тул дахин үнэлгээжүүлэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдох хүсэлтийг гаргахаар төлөвлөн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэн ажиллаж байна гэсэн тайлбарыг үндэслэн аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	-	1	-	-	-
2.3	Тус музейн Ерөнхий нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтод "худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах" гэж заасан нь худалдан авах ажиллагааг	1	-	-	-	1	

Чингис хаан үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	зохион байгуулах чиг үүргийн салангид байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дотоод хяналт хэрэгжихгүй болох эрсдэлтэй байна.						
2.4	Музейн захирлын тушаалаар "Цалин, үндсэн хөрөнгийн нягтлан бодогч" албан тушаалтай ажилтан "Үндсэн хөрөнгө, кассын нярав" гэсэн албан тушаалын албыг хавсран хийж гүйцэтгүүлэхээр тушаал гарган ажиллуулсан нь үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт суларч нэг хүнд ноогдох ажлын байрны ачаалал бий болж, гүйцэтгэлийн чанар буурах эрсдэлтэй байна.	1	-	-	-	1	-
	Дүн	3	-	1	-	2	-
	Нийт дүн	4	153,740.6	2	153,740.6	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 102/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/311/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чингис хаан Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Томилолтоор ажилласан болон ажлаас халагдсан 4 албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан 310,000.00 (гурван зуун арван мянга) төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хавсралт-1-д дурдсан 4 албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон 310,000.00 (гурван зуун арван мянга) төгрөгийг Хүний нөөц хариуцсан ахлах арга зүйч Ж.Алтангэрэл, Захиргаа, санхүү, хамтын ажиллагааны төвийн эрхлэгчийн албан үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Энхтунгалаг, Цалин үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч Б.Урангуа, Ерөнхий нягтлан бодогч Ч.Отгонтуяа, Захирал, академич С.Чулуун тус тус албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг, нотлох баримтын хамт 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингис хаан үндэсний музейн захирал, академич (С.Чулуун), ерөнхий нягтлан бодогч (Ч.Отгонтуяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ПҮРЭВДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 101/А015 0122

Улаанбаатар хот

САГ-2026/311/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чингис хаан Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Чингис хаан Үндэсний музейн захирлын 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн Б/61 дугаартай тушаалаар Батсайханы Өлзийдэлгэрийг Захиргаа, удирдлагын хэлтэст Хуульч, эрх зүйч албан тушаалд үндсэн ажилтнаар ажиллуулахаар томилсон. Тус ажилтан нь 2025 онд гадаад улсад магистр суралцахаар явсан. Зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээтэй тус ажилтанд хоолны хөнгөлөлт 3,320,000.00 (гурван сая гурван зуун хорин мянга) төгрөг, унааны хөнгөлөлт 570,000.00 (таван зуун далан мянга) төгрөг нийт 3,890,000.00 (гурван сая найман зуун ерэн мянга) төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээтэй тус ажилтанд олгосон хоол, унааны хөнгөлөлт нийт 3,890,000.00 (гурван сая найман зуун ерэн мянга) төгрөгийг Хүний нөөц хариуцсан ахлах арга зүйч Ж.Алтангэрэл, Захиргаа, санхүү, хамтын ажиллагааны төвийн эрхлэгчийн албан үүргийг хавсран гүйцэтгэгч Т.Энхтунгалаг, Цалин үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч Б.Урангуа, Ерөнхий нягтлан бодогч Ч.Отгонтуяа, Захирал, академич С.Чулуун тус тус албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг, нотлох баримтын хамт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Чингис хаан үндэсний музейн захирал, академич (С.Чулуун), ерөнхий нягтлан бодогч (Ч.Отгонтуяа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

(Handwritten signature)

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Б.ПҮРЭВДУЛАМ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-61.Docx

1526200056



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 498/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/311/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чингис хаан Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 135 мэдээллээс 126 мэдээллийг тогтоосон хугацаанд, 153,740,573.00 (нэг зуун тавин гурван сая долоон зуун дөчин мянга таван зуун далан гурав) төгрөг бүхий дүнтэй 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Мэдээллийг хоцроож байршуулсан хугацаа нь тус музейн ерөнхий нягтлан бодогч 2 дугаар сарын сүүлээр ажлаа хүлээлгэн өгч, дараагийн ерөнхий нягтлан бодогч томилогдох хугацааны хооронд бөгөөд энэ хооронд шилэн данс хариуцах ажилтан томилоогүй байснаас шалтгаалжээ.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлж байх" гэсэнтэй нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Шилэн дансны мэдээллийг хоцроож байршуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чингис хаан Үндэсний музейн захирал, академич (С.Чулуун) ерөнхий нягтлан бодогч (Ч.Отгонтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Б.ПҮРЭВДУЛАМ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 497/А015 0122

Улаанбаатар хот

САГ-2026/311/КА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чингис хаан Үндэсний музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд өмнөх оны аудитын зөвлөмжөөр 3 автомашины дугаарыг цэнхэр болгож солих тухай зөвлөмж өгснөөс 1 автомашины дугаарыг цэнхэр болгож, 2 автомашины дугаарыг цэнхэр болгож солиогүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийн таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Хоёр автомашины дугаарыг цэнхэр болгоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чингис хаан Үндэсний музейн захирал, академич (С.Чулуун) ерөнхий нягтлан бодогч (Ч.Отгонтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДӨЛГӨӨНХАЙРХАН УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Б.ПҮРЭВДУЛАМ